

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД  
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

**НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА**

Д/д	Шалгуур үзүүлэлт																										
1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> СОДНОМДАВАА <b>Нэр:</b> ТЭГШЖАРГАЛ																										
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b>  Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн /Шинжлэх ухааны арга зүйг ашиглаж макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, хөгжлийн болон салбарын урьдчилсан тооцоолол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийн тооцооллыг хийж, төлөв байдлын таамаглалыг боловсруулах/																										
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн эсэх / <b>ТИЙМ</b> /. Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх / <b>ҮГҮЙ</b> /.																										
1.4	<p><b>Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх:</b></p> <p><b>-эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;</b></p> <table border="1" data-bbox="338 987 1461 1218"> <thead> <tr> <th></th> <th>Суралцсан улс, сургуулийн нэр</th> <th>Элссэн, төгссөн он, сар</th> <th>Эзэмшсэн мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>МУИС-ийн Эдийн засгийн сургууль</td> <td>1997.09</td> <td>Эдийн засгийн ухааны бакалавр</td> </tr> <tr> <td>2</td> <td>Худалдаа үйлдвэрийн их сургууль</td> <td>2004.09</td> <td>Бизнесийн удирдлагын магистр</td> </tr> <tr> <td>3</td> <td>Япон Улсын Хирошимагийн их сургуулийн Олон улсын хөгжил, эдийн засгийн хамтын ажиллагааны сургууль</td> <td>2018.10</td> <td>Шинжлэх ухааны магистр /Master of Science/</td> </tr> </tbody> </table> <p><b>-сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх;</b> 2001-2023 онд улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаагүй болно.</p> <p><b>-зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;</b> Хугацаа хэтэрсэн зээл, өргүй бөгөөд энэ талаарх тодорхойлолтуудыг хавсаргасан.</p> <p><b>-хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;</b> Ёс зүйн аливаа алдаа, дутагдал гаргаж байгаагүй болно.</p> <p><b>-эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно);</li> </ul> <table border="1" data-bbox="338 1832 1461 2022"> <thead> <tr> <th></th> <th>Албан тушаал</th> <th>Ажлын хаяг</th> <th>Ажилласан хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн референт, зөвлөх, ахлах зөвлөх</td> <td>Төрийн ордон</td> <td>2014.11 -2018.07 он, 2022.03 оноос өнөөг хүртэл  5.5 жил</td> </tr> </tbody> </table>				Суралцсан улс, сургуулийн нэр	Элссэн, төгссөн он, сар	Эзэмшсэн мэргэжил	1	МУИС-ийн Эдийн засгийн сургууль	1997.09	Эдийн засгийн ухааны бакалавр	2	Худалдаа үйлдвэрийн их сургууль	2004.09	Бизнесийн удирдлагын магистр	3	Япон Улсын Хирошимагийн их сургуулийн Олон улсын хөгжил, эдийн засгийн хамтын ажиллагааны сургууль	2018.10	Шинжлэх ухааны магистр /Master of Science/		Албан тушаал	Ажлын хаяг	Ажилласан хугацаа	1	УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн референт, зөвлөх, ахлах зөвлөх	Төрийн ордон	2014.11 -2018.07 он, 2022.03 оноос өнөөг хүртэл  5.5 жил
	Суралцсан улс, сургуулийн нэр	Элссэн, төгссөн он, сар	Эзэмшсэн мэргэжил																								
1	МУИС-ийн Эдийн засгийн сургууль	1997.09	Эдийн засгийн ухааны бакалавр																								
2	Худалдаа үйлдвэрийн их сургууль	2004.09	Бизнесийн удирдлагын магистр																								
3	Япон Улсын Хирошимагийн их сургуулийн Олон улсын хөгжил, эдийн засгийн хамтын ажиллагааны сургууль	2018.10	Шинжлэх ухааны магистр /Master of Science/																								
	Албан тушаал	Ажлын хаяг	Ажилласан хугацаа																								
1	УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн референт, зөвлөх, ахлах зөвлөх	Төрийн ордон	2014.11 -2018.07 он, 2022.03 оноос өнөөг хүртэл  5.5 жил																								

	2	Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийн эдийн засгийн онолын багш	МУИС-ийн 4 дүгээр байр	2011-2014.08 он 3 жил
	3	Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн эдийн засгийн онолын багш	МУИС-ийн 8 дугаар байр	2001- 2011 он 10 жил
	4	Үйлдвэр худалдааны яаманд мэргэжилтэн	Засгийн газрын 2-р байр	2002-2010 он 8 жил
	<ul style="list-style-type: none"> <li>• <i>эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.</i></li> </ul>			
		Эрдэм шинжилгээ, судалгааны нэр	Он	Хаана нийтэлсэн
	1	“A necessity of improving livestock market system in Mongolia” сэдэвт илтгэл англи хэл дээр боловсруулж, хэвлүүлсэн. (Ц.Цэцэгмаатай (Ph.D дэд проф), С.Тэгшжаргал)	2010	БНСУ-ын Dankook –ийн их сургуулийн “International Financial Risk Management” сэтгүүлд
	2	<a href="#">Analysing the effects of Mongolia’s accession to Asia-Pacific trade agreement (APTA)</a>  ( <a href="#">CEEOL - Article Detail</a> )	2016	Public administration and regional studies сэтгүүл
1.5	<p><b>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар</b> Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>• -үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>• -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>• -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>• -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;</li> </ul> <p>1. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд шинээр батлагдаж, 2013 онд Төсвийн байнгын хорооны дэргэд Төсвийн шинжилгээний нэгжийг байгуулсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сонгон шалгаруулалтад тэнцэж, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний нэгжид 2014 оны 11 дүгээр сард макро эдийн засаг хариуцсан зөвлөхөөр ажиллаж эхэлсэн бөгөөд 2016 – 2018 онд ахлах зөвлөхөөр ажилласан. 2016 -2018 онд төсвийн шинжилгээний албыг ахалж, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын төсвийн төсөл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрийн мөнгөний бодлогод дүн шинжилгээ хийж, холбогдох байнгын хороодод хүргүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ирсэн. Ажиллаж эхэлснээс хойш Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодыг мэдээллээр хангах зорилгоор өөрийн санаачилгаар макро эдийн засгийн улирлын тойм, гадаад худалдааны сар бүрийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл, мөн нэгдсэн төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн мэдээллийг шинэчлэн боловсруулж, хүргүүлдэг болсон. Эдгээр мэдээллийг гаргадаг болсон нь Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагуудыг төсөв, макро эдийн засаг, гадаад худалдаатай холбоотой мэдээллээр хангахын иргэд, аж ахуйн нэгж, судлаачдад ач холбогдолтой мэдээлэл болсон. 2022 оны 03 дугаар сараас өнөөг хүртэл төсөв, хөгжлийн бодлогын уялдаа нийцлийг хариуцсан референтээр ажиллаж байна.</p> <p>2. БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн алба болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хамтран анхны чуулга хурлыг 2023 оны 10 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан. Чуулга хуралд оролцсон 15 орны төлөөллүүд өөрийн орны Парламентын төсвийн албаны зорилго, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, хийгдэж буй дэвшилттэй ажлууд болон сорилтуудын талаар илтгэл тавьсан. Нэр дэвшигч миний бие Улсын Их Хурлын Төсвийн хяналт, шинжилгээний</p>			

хэлтсийн талаар илтгэж, чуулга хуралд оролцогчдын асуултад хариулсан. Чуулга хурлын үр дүн нь ЭЗХАХБ болон Азийн орнуудын Парламентын төсвийн албадын төсвийн шинжилгээний талаарх сайн туршлагаа хуваалцах, мэдээлэл солилцох платформыг бий болгох, төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр ЭЗХАХБ-ын хамгийн сүүлийн үеийн судалгаанууд, мэдээллийн талаар мэдлэг, туршлагаа хуваалцах зорилготой бөгөөд амжилттай оролцоод ирсэн.

3. Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, Монгол Улсын Их Сургуульд макро эдийн засгийн үндэс, ахисан түвшний макро эдийн засгийн хичээлүүдийг бакалаврын болон магистрын түвшний оюутнуудад заадаг байсан. 2001-2013 оны хугацаанд 20 гаруй илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлж, мөн макро эдийн засгийн бодлого, дасгалын хураамж ном бэлтгэн гаргасан.

4. Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 211 дүгээр тогтоолоор “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийг баталж, хөтөлбөрийн хүрээнд Үйлдвэр, худалдааны яам төслийн нэгжийг байгуулсан. Уг төслийн нэгжид судалгаа хариуцсан мэргэжилтнээр ажиллаж, 15 аймагт бөөний худалдааны төв байгуулах ажлыг зохион байгуулахад оролцсон. Хот, хөдөөгийн үнийн зөрүүг бууруулах, хотын худалдааны соёлыг орон нутагт хүргэх, орон нутгийн иргэдийг чанартай хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр хангах, нөгөө талдаа орон нутгаас малын гаралтай түүхий эдийг бэлтгэн дотоодын үйлдвэрүүдийг тасралтгүй хангахад бөөний төвүүдийн үүрэг чухал байсан.

5. Чухал 3 салбарт эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд төвлөрч байна. Эхний салбар нь худалдаа. Үйлдвэр худалдааны яаманд ажиллаж байсан туршлагад үндэслэн гадаад худалдаа, дотоод худалдаа, цахим худалдаа, бөөний болон жижиглэн худалдаа, худалдаа үйлчилгээний чиглэлээр судалгаа хийж, мөн зарим стандартуудыг шинэчлэн гаргахад оролцож байсан. Төслийн нэгжид ажиллаж байх хугацаанд буюу 2006-2010 онд олон улсын бараа, түүхий эдийн биржийн талаар нэлээдгүй судалж, хөдөө аж ахуйн биржийн тухай хууль 2011 онд батлахад дэмжлэг үзүүлэн ажилласан. 2014 онд Дэлхийн банкны захиалгаар “Экспортлогчдын холбоо” ТББ-ийн судалгааны багтай хамтран “Экспортын хөгжлийн бодлого” сэдвээр судалгааны ажил хийсэн. 2015-2016 онд GIZ байгууллагын санхүүжилтээр “Монгол Улсын АРТА байгууллагад нэгдэн ороход бий болох өөрчлөлтүүд” сэдвээр хамтарсан судалгаа хийж, гадаадын сэтгүүлүүдэд нийтлүүлсэн. Экспортын хөгжлийн бодлого судалгааны үр дүнд уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх талаар төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

6. Хоёр дахь нь уул уурхай, эрдэс баялгийн салбар юм. 2012.06-2014.11 онд Монголын Экспортлогчдын холбоонд судалгаа хариуцсан захирал хийж байх хугацаанд уул уурхайн салбарын эрдэмтэн судлаач нартай хамтран уул уурхайн салбартай холбоотой хэд хэдэн томоохон судалгаа хийгдсэн. Тухайлбал, 2014 онд “Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах боломж”, 2015 онд “Алт 2025” хөтөлбөрийн суурь судалгааны тайланг боловсруулсан. Монгол Улсын эдийн засагт алт хөтөлбөр, уул уурхайн бирж байгуулах нь чухал болох талаар тухайн судалгаанд дурдаж, дүгнэж байв.

7. Гурав дахь сэдэв нь хөдөө аж ахуйн салбартай холбогдоно. Хөдөө аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн биржийн талаар судалж, “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрт ажиллаж байсан туршлага тулгуурлан 2021-2022 онд 2 томоохон судалгаа хийсэн. Тухайлбал, “Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын төсвийн урамшуулал, дэмжлэгийн бодлогын нөлөөллийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажил хийж, уг судалгааны ажлаар НҮБ-ээс ном гаргасан. Мөн Дэлхийн банкны захиалгаар “Монгол улсын хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн стратеги төлөвлөгөө боловсруулах” судалгааны ажил гүйцэтгэсэн.

8. 2015-2023 онд “Татлалцын загвар буюу Gravity model”, Ерөнхий тэнцвэрийн загварчлал, статистик, эконометрикийн шинжилгээ хийх арга зүйгээ сайжруулах зорилгоор гадаад, дотоодын сургалтуудад оролцсон. 2018 онд Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж, 2020 онд “Гадаад худалдаанд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ” сэдвээр магистр хамгаалсан бөгөөд судалгаандаа “Өргөтгөсөн татлалцын загвар буюу augmented gravity model”-ыг ашигласан.

9. Төсвийн шинжилгээний арга зүйг сайжруулах зорилгоор 2022 оноос хойш макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн урьдчилсан таамаглалыг боловсруулахад ашигладаг “Dignar 19 toolkit”, “Fiscal programming”, “Fiscal risk toolkit” зэрэг арга зүйн талаар судалж

	<p>байна. Нээлттэй, жижиг эдийн засагтай орнуудад ашигладаг Олон Улсын Валютын сангаас боловсруулсан эдгээр аргачлалуудыг судалсанаар Монгол Улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцооллуудад ашиглах боломжтой юм.</p> <p>10. “Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын төсвийн урамшуулал, дэмжлэгийн бодлогын нөлөөллийн шинжилгээ” судалгааны хүрээнд 300 малчин, тариаланчдаас санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашиглан анкетан судалгаа авч, SPSS программыг ашиглан үр дүнг гаргасан. Энэхүү аргыг ашиглан анхдагч эх үүсвэрийг ашигласан судалгааны ажлуудыг хийх боломжтой юм.</p>			
1.6	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b>  Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.  -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.  -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>			
		Мэргэжлийн холбооны нэр	Он	Албан тушаал
	1	Монголын экспортлогчдын холбоо	2012-2014	Судалгаа хариуцсан захирал
1.7	<p><b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b>  Хэвлүүлсэн бүтээлийн талаар 2.2-т тусгасан.</p>			
1.8	<p><b>Эрүүгийн хариуцлага</b>  Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/  2001-2023 оны хугацаанд Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй болно. /Эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай тодорхойлолтыг хавсаргав./</p>			
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b>  Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх  2001-2023 оны хугацаанд Үйлдвэр худалдааны яаманд мэргэжилтэн, Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуульд багш, Монгол Улсын Их Сургуульд багш, Улсын Их Хурлын Тамгын газарт референт, зөвлөх, ахлах зөвлөхөөр ажиллаж байх хугацаанд судалгаа, шинжилгээний ажил хийх, удирдлагаас өгөгдсөн ажлыг үр дүнтэй гүйцэтгэхэд анхаарч ажиллаж байсан бөгөөд мөн хугацаанд сахилгын шийтгэл авч байгаагүй болно.</p>			

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p>
	<p>Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, төсвийн шинэчлэл хийгдэж байна. Хуульд зааснаар Төсвийн байнгын хорооны дэргэд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулсан нь төсвийн шинэчлэл хийхэд чухал үүрэгтэй юм. Олон улсад бие даасан төсвийн институт ажилладаг бөгөөд энэ байгууллага нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй адилхан чиг үүрэгтэй. Гадаадын бие даасан төсвийн институт нь бие даасан, аль нэг намаас хараат бус, төсвийн бодлого төлөвлөлт, түүний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, хяналт тавих зорилгыг хангаж, төсвийн ил тол байх, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажилладаг байна.</p> <p>Ил тод байдлыг хангах хүрээнд Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах, олон нийт, эрдэмтэн судлаачдын оролцоотой нээлттэй хэлэлцүүлэг хийх арга хэмжээнүүдийг зохион</p>

	<p>байгуулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлд хяналт тавиж ажиллах болно.</p> <p>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагууд, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд тогтвортой хангагдаж байхад анхаарч ажиллана. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулахдаа улсын хөгжлийн бодлого, төсөв санхүүгийн тогтвортой байдал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх талаар дүн шинжилгээ хийнэ. Мөн төсөв, санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачаалал, мэдрэмжийн шинжилгээ, Засгийн газрын зардлын үржүүлэгчийн шинжилгээ зэрэг төрөл бүрийн шинжилгээ хийж, зарим төрлийн татвар, төсвийн зардалтай холбоотой эдийн засаг, нийгэм болон төсөвт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийнэ.</p> <p>Үүний тулд “Дигнар 19”, “Санхүүгийн программчлал”, “Төсвийн эрсдлийн шинжилгээ” зэрэг аргачлалуудыг ашиглан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахаар тооцоолж байна. Энэхүү аргачлалуудыг ашиглаж гарсан үр дүнг баталгаажуулах зорилгоор салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, ирэх жилүүдийн урьдчилсан төлөвлөлтийн судалгаа хийж, хөгжлийн бодлоготой уялдуулан тооцоолно.</p> <p>“Дигнар 19” арга хэрэгсэл нь эдийн засгийн бодит өсөлт болон Засгийн газрын өрийн байдалд шинжилгээ хийх зорилготой нээлттэй, жижиг эдийн засагтай, байгалийн баялагтай хөгжиж буй эдийн засгийн хувьд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдлыг тодорхойлоход хэрэглэдэг юм.</p> <p>Санхүүгийн программ нь бодит салбар, төсөв болон мөнгөний бодлогын хооронд уялдааг тодорхойлох, эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засаг хаашаа чиглэж байгааг урьдчилан таамаглах, эдийн засгийн чиг хандлагыг өөрчлөх эдийн засгийн бодлогыг тодорхойлоход ашигладаг.</p> <p>“Төсвийн эрсдлийн шинжилгээ” нь төрийн өмчит компаниудын санхүүгийн тайланд тулгуурлан эрсдлийн шинжилгээг хийж, компани, салбарт тулгарч буй аливаа эрсдлүүдийг урьдчилан илэрүүлж, засч сайжруулахад чиглэсэн шинжилгээ юм.</p> <p>БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь 2070 оныг хүртэл хүн амын төлөв байдал, хүн ам зүйн таамаглалыг боловсруулж, энэхүү үндсэн тооцоололд үндэслэн тэтгэвэр, тэтгэмж, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, эдийн засгийн бүтцийн талаар мөн урьдчилан тооцоолол хийж байна. Үүний нэгэн адил судалгааг хийхэд анхаарах болно.</p> <p>Нэр дэвших нь дараах үндэслэлтэй гэж үзэж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний нэгжид олон жил тогтвортой ажиллаж, тус албыг ахалж ажиллаж байсан туршлагатай;</li> <li>2. Үндсэн мэргэжил нь эдийн засагч бөгөөд макро эдийн засаг, улсын төсөв, санхүү, мөнгө, бизнесийн чиглэлээр судалгаа хийж байсан;</li> <li>3. Өөрийн санаачилгаар макро эдийн засгийн улирлын тойм, гадаад худалдааны сар бүрийн гүйцэтгэлийн талаар тогтмол мэдээлдэг болсон.</li> <li>4. Хамтарсан хэд хэдэн судалгаа хийсэн;</li> <li>5. Худалдаа, эрдэс баялаг, хөдөө аж ахуйн чиглэлээр олон судалгаа, илтгэл, өгүүлэл бичсэн;</li> <li>6. Судалгааны арга зүйгээ тогтмол сайжруулж байгаа.</li> </ol>

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: .....

Өөрийн нэр: .....

Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: .....

--- oOo ---